



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/109/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх  
Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.19 № 22

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ӨСӨХБАЯР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тус байгууллага нь МСҮТ-ийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 70 дугаар тушаалаар Үйлдвэр сургалт хариуцсан дэд захирлын орон тоог шинээр бий болгож, нийт 22,966.6 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг олгосон.
2. Цалингийн сангаас нийт 2,465.1 мянган төгрөгийн шагнал урамшуулал, сахилгын шийтгэлтэй албан хаагчид 650.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон.
3. Дотуур байрны хүүхдийн хоолны нормыг 2,054.4 мянган төгрөгөөр, автомашины шатахууны нормыг 1,046.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
4. Тайлант хугацаанд 87 толгой малыг худалдан борлуулж, малаас олсон 14,818.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэл тайланд тусгаагүй байна.
5. Эд хөрөнгийн хяналтын тооллогоор 13 нэр төрлийн 788,1 мянган төгрөгийн ном дутагдсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 498 дүгээр тогтоол, зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн

2019 оны 390 дүгээр тушаалыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2/5264 тоот албан бичгээр байгууллагын нэршил өөрчлөгдсөн, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/64 дүгээр тушаалаар тус байгууллагын удирдлага солигдсон байна.

### **Аудитын гол асуудал**

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан 43.0 хувиар нэмэгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Боловсролын шинжлэх ухааны яамны сайдаас 95.2 хувиар үнэлжээ.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>325,836,834.61</b>	<b>418,255,073.61</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>250,500.00</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>250,500.00</b>	<b>0.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	250,500.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>325,586,334.61</b>	<b>418,255,073.61</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>537,300.00</b>	<b>545,800.00</b>
35130	Эм боох материал	537,300.00	545,800.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5,800,200.00	36,832,700.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>261,388,834.61</b>	<b>339,124,573.61</b>
35410	Бичиг хэргийн материал	1,860,500.00	8,284,930.00
35420	Аж ахуйн материал	22,407,291.00	27,279,481.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,587,000.00	19,097,800.00
35450	Барилгын засварын материал	14,645,181.00	17,015,850.00
35460	Хүнсний материал	871,800.00	231,600.00
35470	Бусад хангамжийн материал	210,017,062.61	267,214,912.61
35600	Мал амьтад	57,860,000.00	41,752,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,593,007,855.74</b>	<b>5,274,957,715.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,593,007,855.74</b>	<b>5,274,957,715.91</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,529,925,855.74</b>	<b>4,210,390,715.91</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,320,301,092.00	3,360,301,092.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-548,259,801.86	-722,835,443.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	491,999,000.00	491,999,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-157,113,390.35	-192,320,017.11
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,083,512,240.95	2,116,402,650.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-875,542,729.76	-1,042,312,361.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,937,021.31	199,982,392.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-157,230,881.49	-147,375,777.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,793,000.00	20,793,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,478,843.75	-13,252,968.75
39217	Ном	139,009,148.69	139,009,148.69
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,063,082,000.00</b>	<b>1,064,567,000.00</b>
39301	Программ хангамж	15,325,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,325,000.00	-165,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,063,082,000.00	1,063,082,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,918,844,690.35</b>	<b>5,693,212,789.52</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,918,844,690.35</b>	<b>5,693,212,789.52</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,918,844,690.35</b>	<b>5,693,212,789.52</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,301,627,386.68	2,301,627,386.68
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,301,627,386.68	2,301,627,386.68
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-6,443,453.22</b>	<b>-232,075,354.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-5,924,916,953.91	-6,443,453.22
51220	Тайлант үеийн үр дүн	5,918,473,500.69	-225,631,900.83

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,623,660,756.89	3,623,660,756.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,918,844,690.35</b>	<b>5,693,212,789.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,296,916,707.21</b>	<b>2,428,713,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,384,392,777.39</b>	<b>116,982,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,384,392,777.39</b>	<b>116,982,900.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,152,000.00</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,052,000.00	0.00
120009	Бусад орлого	0.00	8,105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6,040,318,662.78	45,545,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	340,922,114.61	63,332,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,912,523,929.82</b>	<b>2,311,730,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,716,040,900.00</b>	<b>2,101,049,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,716,040,900.00	2,101,049,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,138,029.82</b>	<b>0.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,138,029.82	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>195,345,000.00</b>	<b>210,681,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,345,000.00	210,681,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,377,696,206.36</b>	<b>2,654,345,500.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,377,696,206.36</b>	<b>2,654,345,500.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,007,624,459.53</b>	<b>2,432,977,805.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,147,327,615.00</b>	<b>1,399,079,641.25</b>
210101	Үндсэн цалин	778,778,281.00	866,450,486.72
210102	Нэмэгдэл	248,975,192.00	313,512,199.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,446,665.00	51,889,902.15
210104	Урамшуулал	72,127,477.00	167,227,052.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,937,644.78</b>	<b>176,772,088.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	99,918,923.41	121,793,740.39
210202	Тэтгэмжийн даатгал	11,748,377.61	14,273,320.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,180,291.51	11,207,456.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,785,620.30	2,681,596.10
210205	Эрүүл мэндийн даатгал	22,304,431.95	26,815,975.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>121,591,351.73</b>	<b>159,422,752.47</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,645,401.73	56,003,672.47
210302	Түлш, халаалт	64,889,000.00	95,322,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,056,950.00	8,097,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,498,169.45</b>	<b>111,142,226.00</b>
210401	Бичиг хэрэг	2,228,500.00	2,055,980.00
210402	Тээвэр, шатахуун	10,093,300.00	11,812,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,881,541.45	4,464,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,750,540.00	5,599,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,263,888.00	15,189,685.00
210408	Бараа материал акталсны зардал	21,280,400.00	72,019,381.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,592,431.00</b>	<b>57,899,311.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	586,252.00	830,520.00

210502	Хоол, хүнс	56,006,179.00	57,068,791.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,670,960.00</b>	<b>25,491,527.88</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	677,500.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	766,000.00
210604	Урсгал засвар	7,993,460.00	24,725,527.88
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>333,200.00</b>	<b>843,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	333,200.00	843,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,372,100.69</b>	<b>13,321,975.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,299,904.69	11,462,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	947,075.00	1,468,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	701,483.00	390,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,423,638.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>468,300,986.88</b>	<b>489,004,482.83</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,737,180.00	82,077,943.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	446,563,806.88	406,926,539.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>370,071,746.83</b>	<b>221,367,695.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>220,122,700.00</b>	<b>108,977,666.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	176,289,500.00	55,622,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,626,000.00	52,199,566.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,207,200.00	1,155,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>149,938,198.56</b>	<b>86,130,949.65</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	149,790,168.74	86,130,949.65
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	148,029.82	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>10,848.27</b>	<b>26,259,079.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,848.27	26,259,079.65
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>5,919,220,500.85</b>	<b>-225,631,900.83</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>747,000.16</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	747,000.16	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>5,918,473,500.69</b>	<b>-225,631,900.83</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,915,675,929.82</b>	<b>2,320,086,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,152,000.00</b>	<b>8,355,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,152,000.00</b>	<b>8,355,500.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,152,000.00</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,052,000.00	0.00
120009	Бусад орлого	0.00	8,355,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,912,523,929.82</b>	<b>2,311,730,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,716,040,900.00</b>	<b>2,101,049,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,716,040,900.00	2,101,049,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,138,029.82</b>	<b>0.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,138,029.82	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>195,345,000.00</b>	<b>210,681,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,345,000.00	210,681,400.00

<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,915,675,929.82</b>	<b>2,276,755,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,915,675,929.82</b>	<b>2,276,755,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,545,604,182.99</b>	<b>2,055,387,504.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,147,327,615.00</b>	<b>1,399,079,641.25</b>
210101	Үндсэн цалин	778,778,281.00	866,450,486.72
210102	Нэмэгдэл	248,975,192.00	313,512,199.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,446,665.00	51,889,902.15
210104	Урамшуулал	72,127,477.00	167,227,052.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,816,955.12</b>	<b>176,772,088.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	99,918,923.48	121,793,740.39
210202	Тэтгэмжийн даатгал	11,748,377.61	14,273,320.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,180,291.51	11,207,456.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,664,930.57	2,681,596.10
210205	Эрүүл мэндийн даатгал	22,304,431.95	26,815,975.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>121,591,351.73</b>	<b>159,422,752.47</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,645,401.73	56,003,672.47
210302	Түлш, халаалт	64,889,000.00	95,322,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,056,950.00	8,097,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,416,527.45</b>	<b>37,798,175.00</b>
210401	Бичиг хэрэг	2,277,500.00	3,425,510.00
210402	Тээвэр, шатахуун	9,143,300.00	11,812,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,065,679.45	6,794,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,760,770.00	5,641,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,169,278.00	10,123,525.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>55,701,201.00</b>	<b>59,125,911.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	586,252.00	900,520.00
210502	Хоол, хүнс	54,059,949.00	56,595,391.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,055,000.00	1,630,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,245,300.00</b>	<b>52,442,467.88</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,572,500.00	770,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	17,885,500.00
210604	Урсгал засвар	5,672,800.00	33,786,967.88
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>333,200.00</b>	<b>843,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	333,200.00	843,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,881,962.69</b>	<b>21,909,475.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,993,904.69	17,924,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	947,075.00	1,468,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	701,483.00	390,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,239,500.00	2,125,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,290,070.00</b>	<b>147,993,193.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,290,070.00	147,993,193.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>370,071,746.83</b>	<b>221,367,695.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>220,122,700.00</b>	<b>108,977,666.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	176,289,500.00	55,622,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,626,000.00	52,199,566.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,207,200.00	1,155,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>149,938,198.56</b>	<b>86,130,949.65</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	149,790,168.74	86,130,949.65
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	148,029.82	0.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>10,848.27</b>	<b>26,259,079.65</b>

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,848.27	26,259,079.65
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0.00</b>	<b>43,331,000.00</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>43,331,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>43,331,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>43,331,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	43,331,000.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>-43,331,000.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-5,924,916,953.91	371,189.66
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,301,627,386.68	3,623,660,756.89	-5,924,916,953.91	371,189.66
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,918,473,500.69	5,918,473,500.69
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-6,443,453.22	5,918,844,690.35
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-6,443,453.22	5,918,844,690.35
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-6,443,453.22	5,918,844,690.35
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-225,631,900.83	-225,631,900.83
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,301,627,386.68	3,623,660,756.89	-232,075,354.05	5,693,212,789.52

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,311,730,700.00</b>	<b>2,207,696,170.70</b>	<b>104,034,529.30</b>	<b>95.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,311,730,700.00</b>	<b>2,207,696,170.70</b>	<b>104,034,529.30</b>	<b>95.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,184,228,400.00</b>	<b>2,098,718,504.70</b>	<b>85,509,895.30</b>	<b>96.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,435,147,100.00</b>	<b>1,399,079,641.25</b>	<b>36,067,458.75</b>	<b>97.49</b>
210101	Үндсэн цалин	836,688,200.00	866,450,486.72	-29,762,286.72	103.56
210102	Нэмэгдэл	424,275,300.00	313,512,199.54	110,763,100.46	73.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,914,300.00	51,889,902.15	-7,975,602.15	118.16
210104	Урамшуулал	130,269,300.00	167,227,052.84	-36,957,752.84	128.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>184,393,400.00</b>	<b>176,772,088.30</b>	<b>7,621,311.70</b>	<b>95.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	125,387,500.00	121,793,740.39	3,593,759.61	97.13
210202	Тэтгэмжийн даатгал	14,751,500.00	14,273,320.25	478,179.75	96.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,801,200.00	11,207,456.12	593,743.88	94.97
210204	Ажилгүйдлийн даатгал	2,950,300.00	2,681,596.10	268,703.90	90.89
210205	Эрүүл мэндийн даатгал	29,502,900.00	26,815,975.44	2,686,924.56	90.89
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>185,681,400.00</b>	<b>159,422,752.47</b>	<b>26,258,647.33</b>	<b>85.86</b>
210301	Гэрэл, цахилгаан	92,001,400.00	56,003,672.47	35,997,727.53	60.87
210302	Түлш, халаалт	86,800,000.00	95,322,000.00	-8,522,000.00	109.82
210303	Цэвэр, бохир ус	6,880,000.00	8,097,080.00	-1,127,080.00	117.69
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,829,700.00</b>	<b>37,798,175.00</b>	<b>31,525.00</b>	<b>99.92</b>
210401	Бичиг хэрэг	4,112,400.00	3,425,510.00	686,890.00	83.30
210402	Тээвэр, шатахуун	11,821,300.00	11,812,900.00	8,400.00	99.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,872,200.00	6,794,960.00	5,077,240.00	57.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,642,800.00	5,641,280.00	1,520.00	99.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,381,000.00	10,123,525.00	-5,742,525.00	231.08
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>72,136,300.00</b>	<b>59,125,911.80</b>	<b>13,010,388.20</b>	<b>81.96</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	909,300.00	900,520.00	8,780.00	99.03
210502	Хоол, хүнс	69,592,300.00	56,595,391.80	12,996,908.20	81.32
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,634,700.00	1,630,000.00	4,700.00	99.71
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>55,211,900.00</b>	<b>54,123,467.88</b>	<b>1,088,432.12</b>	<b>98.03</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,451,100.00	2,451,000.00	100.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,973,100.00	17,885,500.00	1,087,600.00	94.27

210604	Урсгал засвар	33,787,700.00	33,786,967.88	732.12	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,115,400.00</b>	<b>843,800.00</b>	<b>271,600.00</b>	<b>75.65</b>
210702	Дотоод албан томилолт	1,115,400.00	843,800.00	271,600.00	75.65
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>64,670,800.00</b>	<b>63,559,475.00</b>	<b>1,111,325.00</b>	<b>98.28</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,594,600.00	58,231,900.00	362,700.00	99.38
210803	Даатгалын үйлчилгээ	1,476,400.00	1,468,775.00	7,625.00	99.48
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,130,900.00	390,800.00	740,100.00	34.56
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,468,900.00	3,468,000.00	900.00	99.97
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>148,042,400.00</b>	<b>147,993,193.00</b>	<b>49,207.00</b>	<b>99.97</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	148,042,400.00	147,993,193.00	49,207.00	99.97
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>127,502,300.00</b>	<b>108,977,666.00</b>	<b>18,524,634.00</b>	<b>85.47</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>127,502,300.00</b>	<b>108,977,666.00</b>	<b>18,524,634.00</b>	<b>85.47</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,622,600.00	55,622,600.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	70,693,500.00	52,199,566.00	18,493,934.00	73.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,186,200.00	1,155,500.00	30,700.00	97.41
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,311,730,700.00</b>	<b>2,207,696,170.70</b>	<b>104,034,529.30</b>	<b>95.50</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,101,049,300.00</b>	<b>2,023,273,850.35</b>	<b>77,775,449.65</b>	<b>96.30</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,101,049,300.00	2,023,273,850.35	77,775,449.65	96.30
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>210,681,400.00</b>	<b>184,422,320.35</b>	<b>26,259,079.65</b>	<b>87.54</b>
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	210,681,400.00	184,422,320.35	26,259,079.65	87.54
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>73.00</b>	<b>73.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	0.00	100.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй бөгөөд нийт **69,717.6** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 3,751.1 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65,966.5 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 8 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 44,788.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 23,117.3 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 650.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Шатахууны зарцуулалтыг автомашины нормоор тооцон жолоочийн тооцооны хуудсаар тулган шалгахад 1,046.3 мянган төгрөгийн шатахууныг норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулалтыг нормативаар нь тооцож олгоогүйгээс 2,054,464 төгрөгөөр хоол хүнсний материалыг тогтоосон нормативаас хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2022 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 498 дугаар тогтоолын 1-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 (дөрвөн мянга гурван зуун) төгрөгөөр тогтоосугай" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Цалингийн сангаас албан хаагчдад 2,465.1 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 210104 "Төрийн албаны тухай хууль

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажлын үр дүнг сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал ...гэх мэт зардлыг энд бүртгэнэ. Урамшуулал нь ажлын үзүүлэлтээр тооцож хагас бүтэн жилээр цалингийн тодорхой хувиар болон үнэмлэхүй хэмжээгээр тооцон олгох хэлбэртэй байж болно", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төсвийн захирагч дор дурдсан нөхцөлд батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж болно: 2.1.1-т "Төсвийн тогтвортой байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс төсөвт зохицуулалт хийх шаардлага гарсан", 2.1.4-т "Тухайн төсвийн захирагч, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд учирсан хүндрэлийг даван туулахад төсөвт зохицуулалт хийх шаардлага гарсан" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Тус байгууллага нь МСҮТ-ийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 70 дугаар тушаалаар Үйлдвэр сургалт хариуцсан дэд захирлын орон тоог шинээр бий болгож, 6-12 сарын хугацаанд нийт 22,966.6 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно", 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж ... зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" гэж заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, шинэ чиг үүрэг бүхий орон тоог бий болгохгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Тавилга эд хогшил дансанд 30 нэр төрлийн 31 ширхэг 24,928.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.4 Тус байгууллага нийт үндсэн хөрөнгийн 39.7 хувьд нь буюу 429 ширхэг 2,935,415.9 мянган төгрөгийн хөрөнгөд хяналтын тооллогыг хийж гүйцэтгэхэд 13 нэр төрлийн 44 ширхэг 788.1 мянган төгрөгийн ном дутагдсан бодитоор оршин байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6 дахь заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг ажиллуулж хөрөнгө дутагдуулсан буруутай албан хаагчаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.5 Тайлант онд 38,690.0 мянган төгрөгийн 87 толгой малыг худалдан борлуулж, 38,500.0 төгрөгийн орлогыг олсон бөгөөд үүнээс 23,682.0 мянган төгрөгөөр монбелиард үүлдрийн сүү, махны чиглэлийн 3 бярууг худалдан авч, бүртгэлд тусгасан. Үлдэх 14,818.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5-т бүх орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, малаас олсон орлогыг байгууллагын дансанд оруулан, орлогыг бүртгэл тайланд тусгаж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	1	650.3	1	650.3	-	-	-	-	-	-	-	-
Шатахууны зарцуулалттай холбоотой	1	1,046.3	1	1,046.3	-	-	-	-	-	-	-	-
Мал амьтан худалдан борлуулсантай холбоотой	1	14,818.0	-	-	1	14,818.0	-	-	-	-	-	-
Дотуур байрны хүүхдийн хоолны нормтой холбоотой	1	2,054.5	1	2,054.5	-	-	-	-	-	-	-	-
Цалингийн сангаас шагнал олгосонтой холбоотой	1	2,465.1	-	-	1	2,465.1	-	-	-	-	-	-
Хөрөнгө дутагдсантай холбоотой	1	788.1	-	-	1	788.1	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгөтэй холбоотой	1	24,928.7	-	-	1	24,928.7	-	-	-	-	-	-
Шинэ орон тоотой холбоотой	1	22,966.6	-	-	1	22,966.6	-	-	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8</b>	<b>69,717.6</b>	<b>3</b>	<b>3,751.1</b>	<b>5</b>	<b>65,966.5</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-